



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/47/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг , Сайншанд сум 2019 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 90077079 Цахим хаяг: Аудитор: Э.Батчимэг Утас: 99032916 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймаг , Төрийн аудитын газар , Сайншанд сум , Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Г.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА
<u>2019.02.26</u> № <u>1-6/220</u>	
Танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Г.Алтанцэцэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 16-наас 2019 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мандах сумын Хүүхдийн цэцэрлэг нь СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мандах сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд /Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны *Нийт зардал* 122,489.2 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 244.98 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,029.40	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	3,029.40	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 119,856.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 118,614.4 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь төсөв 942.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мандах сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Мандах сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Уртын уул ХХК-с 2,978.0 мян.төгрөгийн авлага тайлагнасан.
2. НДШ-н тайлангаар өр, авлагагүй боловч өглөгтэй гэж тооцоо нийлэн санхүүгийн тайланд өглөг тайлагнасан.
3. ХЧТА-ын тэтгэмж дутуу олгосон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Уртын уул ХХК-с 2,978.0 мян.төгрөгийн авлага тайлагнасан.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Авлага , өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Жилийн эцсийн тодотголоор хөрөнгө шийдэгдсэн тул өвлийн улиралд 380вт хийгдэх боломжгүй болсон. Иймд авлагаар бүртгэсэн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

НДШ-н тайлангаар өр, авлагагүй боловч өглөгтэй гэж тооцоо нийлэн санхүүгийн тайланд өглөг тайлагнасан.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах. НД-н тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт , санхүүгийн тайлантай тулгах нь зүйтэй байна.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тооцоо нийлсэн акт үйлдсэн, санхүүгийн тайланд тусгасан.

3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.3.1 Илрүүлэлт:

Хууль тогтоомжийн дагуу олгож байгаа ХЧТА-ын тэтгэмжийг дутуу олгосон.

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ХХОАТ-ын тухай 16.1.1 заалтыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.1 "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж"-ийг албан татвараас чөлөөлнө гэж заасан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр , тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дах заалтын 1 дэх хэсэгт "хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж"-ийг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөлд хамаарна гэж заасан байна. Иймд ХЧТА-н тэтгэмж нь хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр тул ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.1.-д заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөнө.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2016 оны аудитын шалгалтаар "САЙН АУДИТ" ХХК санхүүгийн тайланд авлага үүсгүүлж тайлагнасан тул татвар суутгасан.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мандах сум
 ᠒᠐᠑᠘

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,308,824.82	37,636,744.82
33	АВЛАГА		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	360,000.00	2,978,000.00
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага		2,978,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,948,824.82	34,658,744.82
351	Түүхий эд материал		
35110	Тусгай зорнуулалттай материал	9,176,903.00	8,403,889.00
354	Хангамжийн материал		
35410	Бичиг хэргийн материал	1,275,800.00	958,750.00
35420	Аж ахуйн материал	14,344,833.82	15,564,915.82
35440	Түлш, шатах тослох материал	2,943,170.00	3,063,250.00
35460	Хүнсний материал	4,208,118.00	6,667,940.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	116,242,607.25	110,909,665.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	116,242,607.25	110,909,665.00
392	Биет хөрөнгө	116,242,607.25	105,805,665.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	218,622,352.00	82,211,570.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,918,372.09)	(433,850.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,329,471.00	34,861,471.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,268,329.61)	(24,358,787.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,685,166.80	21,346,978.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,834,618.65)	(16,649,898.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,164,000.00	8,518,310.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,241,533.20)	(394,599.88)
39217	Ном	704,471.00	704,471.00
393	Биет бус хөрөнгө		5,104,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		5,104,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	148,551,432.07	148,546,409.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	756,000.00	58,353.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	756,000.00	58,353.00
413	Өглөг	756,000.00	58,353.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	756,000.00	58,353.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	147,795,432.07	148,488,056.82
51	Засгийн газрын хувь оролцоо	147,795,432.07	148,488,056.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	55,753,076.30	60,857,076.30
51101	Өмч: - төрийн	55,753,076.30	60,857,076.30
512	Хуримтлагдсан үр дүн	10,421,393.97	9,778,281.09
51210	Өмнөх үеийн үр дүн	10,421,393.97	11,970,818.95
51220	Тайлант үеийн үр дүн		(2,192,537.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,620,961.80	77,852,699.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	148,551,432.07	148,546,409.82

4417144353
 ENQA0056 9025707

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	61,555,002.56	120,296,699.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	443,002.56	439,899.00
120	Нийтлэг татварын бус орлого	443,002.56	439,899.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	443,002.56	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	443,002.56	
120009	Бусад орлого		439,899.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	61,112,000.00	119,856,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	69,504,742.80	122,489,236.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,504,742.80	122,489,236.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,404,742.80	116,168,006.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,241,417.00	72,796,377.00
210101	Үндсэн цалин	40,016,417.00	64,839,265.00
210102	Нэмэгдэл	2,245,000.00	4,041,000.00
210104	Урамшуулал	2,980,000.00	3,916,112.00
2102	Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,976,881.00	8,550,694.00
210201	Тэтгэврийн даатгал	3,167,108.00	6,051,585.00
210202	Тэтгэмжийн даатгал	361,954.00	570,343.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	452,444.00	554,257.00
210204	Ажилгүйдлийн даатгал	90,488.00	124,955.00
210205	Эрүүл мэндийн даатгал	904,887.00	1,249,554.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,823,940.00	5,111,994.00
210301	Гэрэл, цахилгаан	58,740.00	457,724.00
210302	Тулш, халаалт	2,479,000.00	4,288,570.00
210303	Цэвэр, бохир ус	286,200.00	365,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,006,330.00	4,662,499.00
210401	Бичиг хэрэг	203,600.00	1,192,360.00
210402	Тээвэр, шатахуун	1,008,000.00	618,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	201,630.00	370,607.00
210404	Нөм, хэвлэл	21,100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд зүйлс	572,000.00	2,456,932.00
2105	Нормативт зардал	7,717,562.00	11,768,278.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	88,250.00
210502	Хоол, хүнс	7,187,542.00	11,656,428.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	500,020.00	23,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,700.00	49,560.00
210604	Урсгал засвар	185,700.00	49,560.00
2107	Төмийлөлт, зочны зардал	52,000.00	283,300.00
210702	Дотоод албан төмийлөлт	52,000.00	283,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,000.00	278,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,000.00	278,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,287,912.80	12,666,904.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	226,000.00	701,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	6,061,912.80	11,965,104.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	6,321,230.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	5,378,790.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтан ажилласан албан хаагчдад төрөөс олгогдох зардал		5,378,790.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		942,440.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		942,440.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(7,949,740.24)	(2,192,537.86)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(7,949,740.24)	(2,192,537.86)

4417144353
E:QA0056.9025707

СТ-3А

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	61,112,000.00	120,296,699.00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО		439,899.00
120	Нийтлэг татварын бус орлого		439,899.00
120009	Бусад орлого		439,899.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,112,000.00	119,856,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэх санхүүжилт	61,112,000.00	119,856,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА 6н ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	55,261,018.00	116,549,699.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,261,018.00	116,549,699.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,161,018.00	110,228,469.00
2101	Цэвэр хөлс болон нэмэгдэл урамшил	45,241,417.00	72,667,318.00
210101	Үндсэн зардал	40,016,417.00	64,839,265.00
210102	Нэмэгдэл	2,245,000.00	4,041,000.00
210104	Урамшуулал	2,980,000.00	3,787,053.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	4,976,881.00	9,017,400.00
210201	Тэтгэврийн даатгал	3,167,108.00	5,758,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	361,954.00	762,629.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	452,444.00	651,342.00
210204	Ажлын гүйцэтгэлийн даатгал	90,488.00	157,929.00
210205	Эрүүл мэндийн даатгал	904,887.00	1,686,600.00
2103	Байр шингэлтийг холбоотой төгтмөл зардал	823,340.00	5,114,174.00
210301	Гэрэл, шахслаган	485,140.00	457,724.00
210302	Түши, хавалт	52,000.00	4,290,750.00
210303	Цэвэр, бохир ус	286,200.00	365,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	660,830.00	1,989,027.00
210401	Бичиг зэрэг	20,000.00	106,610.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	736,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	201,630.00	370,607.00
210404	Ном, хэвлэл	21,100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мээгэгчдийн устгаа, ариутгал		24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгдэх, ахуйн эд зүйлс	118,100.00	751,310.00
2105	Нормативт зардал	2,811,450.00	14,456,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,400.00	107,250.00
210502	Хоол, хүнс	2,797,050.00	14,116,250.00
210503	Нормын хувцас, зөвлөн эзлэл		232,750.00
2106	Эд хөрөнгө, урсгал засварын зардал	156,000.00	4,487,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,053,000.00
210604	Урсгал засвар	156,000.00	3,434,900.00
2107	Тамилт, зочны зардал	52,000.00	283,300.00
210702	Дотоод албан тэмдэгт	52,000.00	283,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,000.00	373,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,000.00	373,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	326,100.00	1,839,700.00
210902	Хөгжлийн үйлдвэрлэлийн даалгаа хийх	326,100.00	1,839,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	6,321,230.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	5,378,790.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг		5,378,790.00
213209	Нэг удамгийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		942,440.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		942,440.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)+(2)	5,850,982.00	3,747,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		3,747,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,747,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		3,747,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		3,747,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)+(5)		(3,747,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,850,982.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,850,982.00	


4417144353
EIDA0050 8025707

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноон	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрд үлдэгдэл				
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2014 оны 12-р сарын 31-нээрд үлдэгдэл	55,753,076.30	81,620,961.80	10,421,393.97	147,795,432.07
D01	2015 оны 12-р сарын 31-нээрд үлдэгдэл	55,753,076.30	81,620,961.80	10,421,393.97	147,795,432.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,549,424.98	1,549,424.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,753,076.30	81,620,961.80	11,970,818.95	149,344,857.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(3,768,262.37)		(3,768,262.37)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадвал валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн	5,104,000.00		(2,192,537.86)	2,911,462.14
D09	2015 оны 12-р сарын 31-нээрд үлдэгдэл	60,857,076.30	77,852,699.43	9,778,281.09	148,488,056.82



ТГ

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ тогрогор /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эдийн үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,856,800.00	118,914,360.00	(942,440.00)	99.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,856,800.00	118,914,360.00	(942,440.00)	99.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,477,800.00	113,535,570.00	(942,230.00)	99.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,387,300.00	72,227,419.00	(159,881.00)	99.8%
210101	Үндсэн цалин	62,286,300.00	64,399,366.00	2,113,066.00	103.4%
210102	Нэмэгдэл	4,041,000.00	4,041,000.00		100.0%
210104	Урамшуулал	6,060,000.00	3,787,053.00	(2,272,947.00)	62.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,250,500.00	9,017,400.00	(233,100.00)	97.5%
210201	Тэтгэврийн даатгал	5,759,000.00	5,758,900.00	(100.00)	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	873,000.00	762,629.00	(110,371.00)	87.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	698,300.00	651,342.00	(46,958.00)	93.3%
210204	Ажилдүллийн даатгал	174,500.00	157,929.00	(16,571.00)	90.5%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,745,700.00	1,686,600.00	(59,100.00)	96.6%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,114,200.00	5,114,174.00	(26.00)	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	456,000.00	457,724.00	1,724.00	100.4%
210302	Тудал, халаалт	4,298,200.00	4,290,750.00	(7,450.00)	99.8%
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	365,700.00	5,700.00	101.6%
2104	Хянгамж, бараа материалын зардал	2,174,200.00	1,989,027.00	(185,173.00)	91.5%
210401	Бичиг хэрэг	80,000.00	106,610.00	26,610.00	133.3%
210402	Тээвэр, шилжүүл	740,000.00	736,500.00	(3,500.00)	99.5%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	404,200.00	370,607.00	(33,593.00)	91.7%
210404	Нөм, хэвлэл	71,000.00	-	(71,000.00)	0.0%
210405	Хөг хянгамж зайлуулах, харган мэрэгчдийн устгаа, ариутгал	160,000.00	24,000.00	(136,000.00)	15.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	719,000.00	751,310.00	32,310.00	104.5%
2105	Норматив зардал	14,914,300.00	14,456,250.00	(458,050.00)	96.9%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	107,250.00	67,250.00	268.1%
210502	Хоол, хүнс	14,574,300.00	14,116,250.00	(458,050.00)	96.9%
210503	Нормын хувиц, зөвлөн эдлэл	300,000.00	232,750.00	(67,250.00)	77.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,579,600.00	8,234,900.00	(344,700.00)	96.0%
210601	Багж, техник, хэрэгсэл	4,800,000.00	4,800,000.00		100.0%
210604	Урсгал засвар	3,779,600.00	3,434,900.00	(344,700.00)	90.9%
2107	Төмнөлт, зочны зардал	283,300.00	283,300.00		100.0%
210702	Дотоод албан төмнөлт	283,300.00	283,300.00		100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,400.00	373,400.00		100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	373,400.00	373,400.00		100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,401,000.00	1,839,700.00	438,700.00	131.3%
210902	Хянгамж үйлдвэрлэлийн далага хийх	1,401,000.00	1,839,700.00	438,700.00	131.3%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,379,000.00	5,378,790.00	(210.00)	100.0%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,379,000.00	5,378,790.00	(210.00)	100.0%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,379,000.00	5,378,790.00	(210.00)	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,856,800.00	119,856,800.00		100.0%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,856,800.00	119,856,800.00		100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	119,856,800.00	119,856,800.00		100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	12		100.0%
620001	Удирлах ажилтан	1	1		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0%
620003	Үйлчлэх ажилтан	7	7		100.0%
620004	Гэрээт ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)				
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙДВЭРЛЭЛИЙН ТӨВ				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

4417144353
EHOA0056 982578